1.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн ус цэвэршүүлэгчийн хэвийн үйл ажиллагааг хангах, стандарт хугацаанд шүүлтүүрийг тогтмол солих, шалгаж цэвэрлэх шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээ хийх ажлыг гүйцэтгэх /цаашид "Гэрээт ажил" гэх/ ба Захиалагч нь Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Талууд энэхүү гэрээний дагуу ажиллахдаа Монгол Улсын хууль тогтоомж болон гэрээний заалт бүрийг дагаж мөрдөнө.

1.3 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг аль нэг тал гаргавал хоёр тал харилцан тохирлоцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ. Нэмэлт өөрчлөлт хавсралт нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд түүнтэй нэгэн адил хүчинтэй байна.

1.4 Талууд аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

**Хоёр: Гэрээгээр гүйцэтгэх ажил**

2.1 Гэрээгээр гүйцэтгэгч нь ус цэвэршүүлэгч аппаратны эвдрэл гэмтлийг оношлон захиалагчид үзүүлж хянуулан засварлахаас гадна шүүлтүүрүүдийг энэхүү гэрээний 4.1-д заасан хугацааны дагуу солино.

2.2 Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ энэхүү гэрээний 2.1-д заасан ажлыг тогтоосон хугацаанд сольж аливаа доголдол гарсан тохиолдолд тохиолдолд захиалагчийн дуудлага өгсөн хугацаанд хурдан шуурхай чанарын өндөр түвшинд элдэв доголдолгүйгээр засварлана.

**Гурав: Гэрээний хугацаа**

3.1 Талууд гэрээг харилцан зөвшөөрч гэрээнд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

3.2 Энэхүү гэрээг 2023 оны 03 дүгээр сарын 24 ны өдрөөс 2023 оны 05 дүгээр сарын 01 ны өдөр хүртэл хугацаатай байгуулав.

**Дөрөв:Төлбөр тооцоо**

4.1 Эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд захиалагчийн дуудлага өгсөн хугацаанд хурдан шуурхай чанарын өндөр түвшинд хийж гүйцэттэх бөгөөд засварласан үйлчилгээний төлбөрийг дараагийн шүүлтүүр солих мөнгөн дүн дээр нэмж бичнэ.

4.2 Гүйцэтгэгчийн шүүлтүүрийг солих буюу эвдрэлийг зассан төлбөрийн нэхэмжлэхийг үндэслэн Голомт банк - 1415107152 тоот дансанд буюу бэлнээр тооцоо хийнэ.

4.3 Усны шүүлтүүрийн үнэ. Энэхүү үнэд шүүлтүүрийн үндсэн үнэ, суурилуулалтын үнэ, НӨАТ болон холбогдох бусад татвар хураамжууд бүгд багтсан болно.

| **д/д** | **Шүүлтүүрийн нэр** | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| **1** | Чулуун шүүлтүүр | 450 кг | 11'000 | **4'950'000** |
| **2** | Нүүрсэн шүүлтүүр | 150 кг | 13'000 | **1'950'000** |
| **3** | **Q2 бодис** | 250 кг | 18'000 | **4'500'000** |
| | | | | |
| | | | | |
| | | | Нийт дүн | **11'400'000** |

**Тав: Захиалагчийн эрх, үүрэг**

5.1 Ажлын явц, ажлын чанарт байнгын хяналт тавих, Гүйцэтгэгчтэй харьцаж байх хүнийг хариуцуулан ажиллуулах үүрэгтэй.

5.2 Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй буюу зөрчсөнөөс учирсан хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй.

5.3 Захиалагч нь гэрээгээр тохирсон чанар бүхий ажлын гүйцэтгэлийг хүлээн авах үүрэгтэй.

5.4 Тогтоосон хугацаанд шүүлтүүрийг солиулахаар шаардлага гаргах эрхтэй.

5.5 Ус цэвэршүүлэгч аппаратыг ашиглах зааавартай нарийн танилцаж, хориглосон болон анхааруулсан зүйлүүдийг ажилчиддаа сануулах үүрэгтэй.

5.6 Үйлчилгээний хөлсийг ажлын 7-14 хоногт багтаан шилжүүлэх үүрэгтэй.

5.7 Гүйцэтгэгчийг гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

**Зургаа: Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

6.1 Энэхүү гэрээнд заасан хугацаанд усны шүүлтүүрийг сольж шүүлтүүрийг цэвэрлэж ус цэвэршүүлэгч хэвийн ажиллаж буй эсэхэд хяналт тавина.

6.2 Ус цэвэршүүлэгч эвдэрсэн болон аливаа доголдол гарсан тохиолдолд оношилж, шаардлагатай сэлбэг хэрэгслээр солих, засварлах ажлыг дуудлага өгснөөс хойш 2 хоногийн дотор цаг алдалгүй гүйцэтгэх үүрэгтэй.
6.3 Ажил эхлэхэд шаардагдах мэдээллийг бүрэн өгөхийг Захиалагчаас шаардах эрхтэй.
6.4 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээн авахыг Захиалагчаас шаардах эрхтэй.
6.5 Захиалагчийг гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
6.6 Энэхүү гэрээний 2 дугаар зүйлд заасан ажлыг тогтоосон хугацаа бүрт, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх үүрэгтэй.
6.7 Энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс Захиалагчид учирсан хохирлийг бүрэн хариуцах үүрэгтэй.
6.8 Захиалагчийн хариуцуулсан эрх бүхий ажилтанд ажлын гүйцэтгэлийг байнга танилцуулах үүрэгтэй.

**Долоо: Талуудын хүлээх хариуцлага**

7.1 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс нөгөө талд учирсан хохирлыг бүрэн хариуцаж арилгах үүрэгтэй.
7.2 Талууд гэрээнд заасны дагуу үйлчилгээг цаг тухайд нь гүйцэтгүүлэх ба гүйцэтгүүлээгүй тохиолдолд Гүйцэтгэгч тал хариуцлага хүлээхгүй болно.
7.3 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй бол гэрээг цуцалж гэрээний үнийн дүнгийн 0,5 хувиар тооцож нөгөө талдаа торгууль төлнө.

**Найм: Бусад зүйл**

8.1 Энэхүү гэрээтэй холбогдон үүссэн аливаа санал, зөрөлдөөн маргааныг гэрээг байгуулсан эрх бүхий этгээдүүд эвийн журмаар шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хуулийн дагуу харьяа шүүхээр шийдвэрлүүлнэ.
8.2 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж Захиалагч 1 хувь Гүйцэтгэгч 1 хувийг хадгална.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

Гүйцэтгэгчийг төлөөлж:
Инженер:Ц.Дашдорж
Гарын үсэг/........................../
Утас: 99074336

Захиалагчийг төлөөлж:
Ерөнхий инженер: Ч.Аюурзана
Гарын үсэг/........................../
Утас: 89119096

**Талуудын албан ёсны хаяг**

Улаанбаатар хот
СХД 28-р хороо

Улаанбаатар хот БЗД 11-р хороо
хонхор 82тоот

Үндэсний тоон гарын үсгээр баталгаажуулав CLASS III
Норовням НАРАНТУЯА
narantuya5818@gmail.co
Өмгөөллийн авинекс па
Захиргаа

# ГЭРЭЭНИЙ ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН ХУУДАС

~~PD-2023-013~~
PD-2023-001

ЗАРЛАГЫН ГЭРЭЭ

Компанийн нэр: Сэнтрал фүүдс ХХК
Гэрээний төрөл: Үйлчилгээ Үзүүлэх Гэрээ

| | | |
|---|---|---|
| 1. ГЭРЭЭЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ | | |
| | Нэр: | Улаанбаатар шинэчлэл ХХК |
| | Регистрийн дугаар: | 5183363 |
| | Хаяг: | Улаанбаатар жалханц хутагт дамдинбазар, 37, 5 тоот |
| | Утас: | |
| | Данс: | ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК : 2811187424 \| Төгрөг |
| | НӨАТ төлөгч эсэх : | Үгүй |
| 2 ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ | | |
| | Гэрээний нэр: | Тээврийн үйлчилгээ үзүүлэх гэрээ |
| | Гэрээний зүйл: | Хог тээвэр |
| | Гэрээний хугацаа: | Эхлэх хугацаа: 2023-01-01 Дуусах огноо : |
| | Автоматаар сунгагдах эсэх: | Үгүй |
| | Гэрээний чиглэл: | Туслах гүйцэтгэгч |
| 3. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ | | |
| | Төлбөрийн давтамж: | Сар бүр |
| | Нийт төлбөр: | 560,000.00 (MNT) |
| | Төлбөрийн хэлбэр: | Бэлэн бус |
| | Татварын мэдээлэл: | НӨАТ |
| | Төсөвтэй эсэх: | Тийм |
| | Төсвөөс хэтэрсэн эсэх: | Үгүй |
| | Төлбөр төлөх хуваарь: | Төрөл \| Хувь \| Дүн \| Валют<br>Сарын төлбөр \| 100.00 \| 560,000.00 \| MNT |
| | Алданги, торгууль: | Үндэслэл \| Хувь |
| 4. БУСАД | | |
| | Нэмэлт гэрээ эсэх: | Байхгүй |
| | Өөрчлөгдсөн нөхцөл: | |
| | Нэмэлт тайлбар: | Хог тээвэр болон Үнс тээвэр хамт |
| | Өмнө гэрээ байгуулж байсан эсэх | Тийм |
| 5. ХЯНАЛТЫН САМБАР | | |
| | Гэрээний менежер | Г.Үндраа/Чанарын менежер/ 2023-01-30 10:57:04 |
| | Хариуцсан алба, нэгжийн хяналт | |
| | Санхүүгийн хяналт | Б.Бат-Ирээдүй/Үйл ажиллагаа дэмжих газрын захирал/ 2023-01-30 14:59:48 |
| | Хуулийн хяналт | Ө Авинекс партнерс ХХК 2023-01-31 14:40:53 |
| | Хариуцсан захирал, албаны дарга баталсан | Д.Жүгдэрнамжил/Гүйцэтгэх захирал/ 2023-02-08 14:59:12 |
| | Гүйцэтгэх захирал баталсан | Д.Жүгдэрнамжил/Гүйцэтгэх захирал/ 2023-02-08 17:40:12 |

**Батлав.**
"СЭНТРАЛ ФҮҮДС" ХХК
Гүйцэтгэх захирал
................................/Д.ЖҮГДЭРНАМЖИЛ/

**Батлав.**
"УЛААНБААТАР ШИНЭЧЛЭЛ" ХХК
Гүйцэтгэх захирал
................................/Б.ЭРДЭНЭСАЙХАН/

# ХОГ ХАЯГДЛЫГ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 01-р сарын 01-ний өдөр №  Улаанбаатар хот

Энэхүү Хог Хаягдлыг Тээвэрлэх гэрээ (цаашид "**Гэрээ**" гэх)-г нэг талаас "Сэнтрал фүүдс" ХХК /цаашид "**Захиалагч**" гэх/, түүний төлөөлж Чанарын алба хариуцсан менежер Г.Ундраа, нөгөө талаас "Улаанбаатар шинэчлэл" ХХК /цаашид "**Гүйцэтгэгч**" гэх/, түүнийг төлөөлж Орлого Хариуцсан Байцаагч А.Намуундарь нар Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийг удирдлага болгон энэхүү гэрээг харилцан тохиролцож байгуулав.

## *Нэг. Нийтлэг Үндэслэл*

1.1 Энэхүү гэрээгээр гүйцэтгэгч нь захиалагчийн заасан газраас хог хаягдал цуглуулах, тээвэрлэх ажлыг өөрийн техник хэрэгслээр тээвэрлэн зориулалтын газарт байршуулах, Захиалагч нь гэрээгээр тохиролцсон хөлс төлөхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.
1.2 Гүйцэтгэгч байгууллага нь Хог хаягдлын тухай хулуийн 8.1.9б, 14.2 хэсэгт заасан Хог хаягдлын үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийг төрийн зохих байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр энэхүү гэрээг байгуулж байгаа болно.
1.3 Энэхүү Гэрээний хүчин төгөлдөр хугацаанд Гүйцэтгэгч нь Гэрээний 1.2-т заасан бүртгэлийн хүчин төгөлдөр байдлыг ханган ажиллах бөгөөд харьяа дүүргийн Засаг даргын баталсан дүрэм, журмыг баримтлан ажиллана.
1.4 Энэхүү Гэрээний хүрээнд дараах Хавсралтыг баталж байх бөгөөд энэ нь гэрээний салшгүй нэг хэсэг болно. Үүнд:
    1.4.1 Хавсралт№1- "Захиалагчийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэн ачих байршил, график",
    1.4.2 Хавсралт№2- Гүйцэтгэгч байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, Хог хаягдал цуглуулах, ачих бүртгэл хийсэн талаар баримт,
    1.4.3 Хавсралт№3- Гүйцэтгэгч байгууллагын ажил гүйцэтгэх тээврийн хэрэгслийн мэдээлэл, жолоочийн иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх, сургалтын гэрчилгээ,

## *Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг*

2.1. Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийн 5.1, 5.2 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Захиалагч нь хог цуглуулах, тээвэрлэх, үнс ачих ажлыг "УЛААНБААТАР ШИНЭЧЛЭЛ" ХХК-иар гүйцэтгүүлж, гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын төлбөрийн төлнө.
2.2. Захиалагч нь цаашид шаардлага хангасан зориулалтын битүү болон задгай, замын хөдөлгөөний аюулгүй байдлын нөхцөлүүдийг хангасан тээврийн хэрэгсэлтэй, ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл болон шаардлагатай багаж хэрэгслээр хангагдсан бусад аж ахуйн нэгж, албан байгууллагатай хог хаягдлыг зөөн тээвэрлэх гэрээ байгуулан, ажиллах эрхтэй.
2.3. Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагын ажлыг тогтсон цаг хугацаанд нь тээвэрлэж байгаа эсэхэд хяналт тавьж сар бүр дуудлага болон тогтсон хуваарийн дагуу тээвэрлүүлнэ.
2.4. Тогтсон хуваарийн дагуу хог тээврийн машин ачилт хийхээр очиход үнс, хог байхгүй гэж ачилт хийлгээгүй буцаасан үед тухайн үеийн төлбөрийг ачилт хийснээр тооцож захиалагч тал хариуцна.
2.5. Хуульд заасны дагуу хог хаягдал тээвэрлүүлсэний төлбөрийг цаг хугацаанд нь бүрэн төлнө.
2.6. Захиалагч нь өөрийн тодорхойлсон зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх үүрэгтэй.

2.7. Захиалагч үүсгэсэн хог хаягдлаа хадгалах түр цэгт ангилан хаях үүрэгтэй.
2.8. Хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн зөвлөлгөө, хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.
2.9. Гүйцэтгэгч байгууллагыг гэрээний дагуу ажил үүргээ шаардлагын түвшинд гүйцэтгээгүй, аливаа иргэд байгууллагаас санал гомдол гарсан тохиолдолд хог тээврийн графикийг тээвэрлэгч тал зөрчсөн, захиалагчийн үйл ажиллагаанд санхүүгийн хохирол учирвал тээвэрлэгчээр хохирлыг барагдуулахыг шаардах, буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх эрхтэй.
2.10. Захиалагч нь гүйцэтгэгч талд хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэн зайлуулах ажлын гүйцэтгэлийг хянаж үзээд, тооцоо нийлэх бөгөөд төлбөрийг нэхэмжилсэн өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан шилжүүлнэ. Хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.2%-ийн алданги төлнө.
2.11. Захиалагч талын хог хаягдлыг хариуцсан албан тушаалтан хог хаягдлын талаархи мэдээллийг гүйцэтгэгч талд мэдэгдэж машин захиалж ачуулах ба ачилтанд өөрийн биеэр хяналт тавьж хоггүй орчин бүрдүүлэх үүрэг хүлээнэ.
2.12. Захиалагч талаас хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэн ачихад өөрийн зүгээс шаардлагатай гэсэн шаардлагыг тавих эрхтэй бөгөөд энэ талаар Гүйцэтгэгч байгууллагын удирдлагад мэдэгдэнэ.

## *Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг*

3.1. Гүйцэтгэгч нь Захиалагчийн энгийн хог хаягдлыг тээвэрлэлтийн гэрээнд заасан хугацаа болон Захиалагчийн баталсан график, хуваарийн дагуу ачиж тээвэрлэх ажил үйлчилгээг гүйцэтгэнэ.
3.2. Энгийн хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэх үүрэгтэй ба Захиалагчийн талбайгаас хог хаягдлыг зайлуулах тээврийн хэрэгсэл нь задгай бүхээгтэй байна.
3.3. Энгийн хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нь зохих сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байна.
3.4. Гүйцэтгэгч нь шаардлага хангасан зориулалтын битүү болон задгай, замын хөдөлгөөний аюулгүй байдлын нөхцөлүүдийг хангасан тээврийн хэрэгсэлтэй байх ба ажилчид нь ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл (бохир хог хаягдлаас хамгаалах хувцас, маск) болон шаардлагатай багаж хэрэгслээр бүрэн тоноглогдсон байна.
3.5. Гүйцэтгэгч нь хог хаягдлыг ачиж тээвэрлэх үедээ харилцааны соёлыг эрхэмлэн, иргэд байгууллагатай зөв зохистой харьцана..
3.6. Гүйцэтгэгч нь Захиалагчаас нэмэлтээр ажил үйлчилгээ авах, нийтийг хамарсан арга хэмжээнд холбогдох ажил үйлчилгээ авах хүсэлтэй тохиолдолд энэ талаар Гүйцэтгэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр гүйцэтгүүлж болно.
3.7. Гүйцэтгэгч нь захиалагчаас гарсан ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ Нийслэлийн ИТХ-ийн шийдвэр, журамд заасны дагуух тарифаар гүйцэтгэнэ. Овор ихтэй, хүнд, барилгын хог хаягдлыг тээвэрлэн зайлуулахдаа тухайн хог хаягдлыг гаргасан хувь хүн, албан байгууллага, аж ахуйн нэгжтэй үнэ тарифийн талаар урьдчилан харилцан тохиролцож журамд зааснаас бусад тарифаар тээвэрлэнэ.
3.8. Гүйцэтгэгч нь хог хаягдлыг хаях товлорсон, улсаас тогтоосон цэгт маршрутын дагуу тээвэрлэн хүргэнэ.
3.9. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн ажлаа хийж гүйцэтгэсний төлбөрөө цаг хугацаанд нь нэхэмжлэх эрхтэй. Хэрвээ гүйцэтгэгч тал нь хог тээвэрлэлтийн ажлыг баталж өгсөн графикийн дагуу цаг хугацаанд нь ачиж тээвэрлэх бөгөөд график зөрчигдсөн болон гэрээнд заасан үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд хариуцлага хүлээнэ.
3.10. Захиалагч байгууллагаас нэхэмжилсэн хог тээвэрлэх зардлыг заасан хугацаанд санхүүжүүлээгүйн улмаас үүсэн хохирлыг гүйцэтгэгч тал хариуцахгүй.
3.11. Гүйцэтгэгч тал нь ажил үйлчилгээ явуулсанаас бусдад учруулсан хохирлыг өөрсдөө хариуцан арилгах үүрэг хүлээнэ.
3.12. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас аж ахуйн нэгж, байгууллагад учруулсан аливаа хохирол, нэмэлт зардал, аж ахуйн нэгж, байгууллагын нэр хүндийг гутаасан аливаа үйлдлийг хариуцан арилгах үүрэг хүлээнэ.
3.13. Гүйцэтгэгч нь хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үед түүнийг унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга хэмжээ авч Захиалагчтай хамтран ажиллана.

3.14. Гүйцэтгэгч нь хог хаягдлыг галын аюулгүй ажиллагаа, замын хөдөлгөөний аюулгүй байдал дүрэм журмыг бүрэн хангаж ажиллана.
3.15. Хог ачсаны дараа эргэн тойронд задгай хог хаягдал орхихгүй, бүхэлд нь ачсан байна.
3.16. Гүйцэтгэгч нь хог хаягдлыг ачихаар ирсэн тээврийн хэрэгслийг аливаа бусад этгээдийн хог хаягдалгүй, хоосон суллаж ирсэн байна.

## Дөров. Тээвэрлэх ачааны хэмжээ, үнэлгээ

4.1. Гэрээнд заасан аж ахуйн нэгжийн хогийг тээвэрлэхдээ замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагуудыг хангасан задгай болон битүү шахлаг тээврийн хэрэгслээр тээвэрлэж, дуудлага рейсээр тооцно.
4.2. Гэрээт хугацаанд сар бүр дуудлагаар Захиалагчийн хог хаягдлыг тээвэрлэнэ. Хог тээвэрлэсний төлбөр нь доорхи хүснэгтийн дагуу байна.

| Машины даац /тн/ | 1 рейсийн үнэлгээ /₮/ | Зориулалт | Байршил | Үнэлгээ |
|---|---|---|---|---|
| 5тн /задгай/ | 260,000₮ | Хог ачилт | Хонхор | Дуудлагаар |
| 10тн /задгай/ | 300,000₮ | Үнс ачилт (*Ачих механизм ороогүй зөвхөн үнс ачилт*) | Хонхор | |

4.3. Төлбөрийг гүйцэтгэгчийн Худалдаа хөгжлийн банкны 2611187424 тоот дансанд төлнө.
4.4. Чиргүүлтэй тээврийн хэрэгслийн чиргүүлд ачсан хогийг 1 рейс гэж үзэх ба Гэрээний 4.2-д заасны дагуу тооцно.
4.5. Нийтийг хамарсан их цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг Гэрээний 4.1 болон 4.2-т заасныаар тооцож төлнө.
4.6. Хог тээврийн баримтыг бүрдүүлэхдээ машин бүрээр тээврийн дагалдах, тооцооны хуудас хөтлөх ба тухайн тээврийн хэрэгслийн тооцооны хуудсыг буруу хөтөлсөн тохиолдолд зохих хариуцлага хүлээлгэнэ.

## Тав. Байгал орчны ба аюулгүй ажиллагааны талаар

5.1. Захиалагч нь гүйцэтгэгчийг ажил үүргээ эхлэхийн өмнө гүйцэтгэх ажлын онцлогоос хамаарч байгал орчны болон аюулгүй ажиллагааны дүрэм журмыг танилцуулна.
5.2. Гүйцэтгэгч нь гэрээт ажил үүргийг гүйцэтгэх хугацааны туршид захиалагчийн аюулгүй ажиллагааны болон галын аюулгүй байдал, байгал орчны хяналтын дүрэм, журмыг баримтлан ажиллах бөгөөд түүнтэй холбогдон гарах бүхий л асуудлыг өөрөө бүрэн хариуцна.
5.3. Гүйцэтгэгч нь өөрийн ажиллагсадын аюулгүй байдлыг хариуцах хүнийг томилох, хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслийн хангалт, багаж, тоног төхөөрөмжийн хэвийн аюулгүй ажиллагаа учирч болох эрсдэлүүд тэдгээрээс хамгаалах арга хэмжээг авах үүрэгтэй.
5.4. Гүйцэтгэгчийн тухайн ажилд ашиглагдаж буй материалын хадгалалт, хамгаалалтыг бүрэн хариуцан ажиллах бөгөөд тухайн ажлаас гарсан хог хаягдлыг хууль журмын дагуу хаяж устгах хүрээлэн буй орчинд бохирдол үүсгэж буй эсэхээ хянаж ажиллана.
5.5. Гүйцэтгэгч нь аюултай бодис асгарч гоожихоос хамгаалсан төхөөрөмжтэй байх бөгөөд, хэрэв аюултай бодис хэрэглэж байгаа бол урьдчилан эрх бүхий байгууллагаас хэрэглэх зөвшөөрөл авсан байх шаардлагатай.
5.6. Захиалагч нь тусгай зөвшөөрөлтэй ажиллах ажил үүрэг гүйцэтгэх тохиолдолд эрх бүхий байгууллагаас авсан зөвшөөрлийн баталгаажсан бичиг баримттай байхыг гүйцэтгэгчээс шаардана.
5.7. Гүйцэтгэгч нь үйлдвэрлэлийн осол гарахаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч ажиллах бөгөөд гарсан ослын талаар Захиалагч талд болон мэргэжлийн байгууллагад үнэн зөв, мэдээлэл өгөх үүрэгтэй.

## Зургаа. Хариуцлага болон Гэрээ цуцлах үндэслэл

6.1. Талууд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө талаас бичгээр уг зөрчлийг арилгах нэмэлт хугацаа олгож болно.
6.2. Нэмэлт хугацаа Захиалагч талаас олгох шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд энэ талаар нөгөө талдаа бичгээр мэдэгдэх бөгөөд уг зөрчлийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлсэн тохиолдолд гарсан зардлыг Гүйцэтгэгч талаас шууд нэхэмжилнэ.
6.3. Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлээгүй тохиолдолд энэхүү гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн хоног тутамд 0,1 хувийн алдангийг төлнө.
6.4. Талуудын аль нэг тал нөгөө талдаа бичгээр 15 хоногийн өмнө мэдэгдэх өгснөөр энэхүү Гэрээг нэг талын санаачилгаар цуцалж болно. Цуцлах үндэслэлд дараах хамаарч байна. Үүнд:
   - 6.4.1. Аль нэг тал гэрээний үүргээ ноцтой зөрчсөн гэж үзсэн,
   - 6.4.2. Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бөгөөд зөрчлийг арилгах нэмэлт хугацаа олгосон боловч зөрчлийг зохих ёсоор арилгаагүй,
   - 6.4.3. Гүйцэтгэгч талын төрийн байгууллагаас авсан зөвшөөрөл болон бүртгэл хүчингүй болсон, хугацаа дуусгавар болсон,
   - 6.4.4. Гэрээний шинэчлэсэн үнийн тарифыг Захиалагч талаас хүлээн авах боломжгүй гэж үзсэн,
   - 6.4.5. Хуульд заасан бусад үндэслэл.

6.5. Энэхүү Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцалсан нь гэрээний хугацаанд гүйцэтгэх ёстой байсан үүргээ чөлөөлөх үндэслэл болохгүй.

## ***Долоо. Бусад заалт***

7.1. Гэрээнд хоёр талын эрх бүхий этгээд гарын үсэг зурж тамга дарсанаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно.
7.2. Санал, гомдол үнэн бодит мэдээлэл дээр үндэслэсэн эсэхэд хоёр тал хяналт тавьж гарсан хохирлыг буруутай тал хариуцаж гомдлыг барагдуулна. Аливаа санал, гомдлыг нөгөө талдаа бичгээр 15 хоногийн дотор мэдэгдэнэ.
7.3. Хог тээвэрлэлтийн тарифанд өөрчлөлт орох зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хоёр тал харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
7.4. Гэрээг талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр нэмэлт өөрчлөлт оруулах эрхгүй бөгөөд зайлшгүй цуцлах тохиолдолд 30 хоногийн өмнө, нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд ажлын 5 хоногийн өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
7.5. Захиалагч гүйцэтгэгч талууд нь харилцан бие биедээ хүндэтгэлтэй хандаж, бие биенийхээ ажлыг дэмжих зарчим баримтлах ба аливаа маргаантай асуудлыг зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд 30 хоногийн дотор эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд хууль хяналтын байгууллага, шүүхээр шийдвэрлүүлж болно.
7.6. Гэрээг хоёр тал жилийн эцэст дүгнэн гэрээг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, сунгах асуудлыг шийдвэрлэнэ.
7.7. Гэрээ нь 2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2023 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Гэрээг сунгах тохиолдолд Талууд харилцан тохиролцсоны дагуу бичгээр сунгана.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** | **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** |
|---|---|
| "Сэнтрал Фүүдс" ХХК | "Улаанбаатар Шинэчлэл" ХХК |
| Чанарын алба хариуцсан менежер | Орлого Хариуцсан Байцаагч |
| Г.Ундраа | А.Намуундарь |
| ............................................ | ............................................ |
| УТАС: 80893001, 88016133 | УТАС: 77015050, 94505053, 94505050 |
| ХАЯГ: Баянзүрх дүүрэг, 11-р хороо, Хонхор-82 | ХАЯГ: Баянгол дүүрэг, 18-р хороо, Жалханзхутагт, Дамдинбазарын гудамж 37-5 тоот |

Норовням НАРАНТУЯА
narantuya5818@gmail.co
Өмгөөллийн авинекс па
Захиргаа

"УЛААНБААТАР ШИНЭЧЛЭЛ" ХХК

*Хавсралт №1*

"СЭНТРАЛ ФҮҮДС" ХХК-ний хог хаягдлыг ачиж тээвэрлэх, буулгах байршил

2023 он

| Тээврийн хэрэгслийн дугаар | Хог хаягдал ачих автомашины хөдлөх байршил | Хог хаягдал ачих байршил | Хог хаягдал буулгах байршил |
|---|---|---|---|
| 0757 УАМ | СХД-ийн 36-р хороо Алтан овоо хэсэг "Улаанбаатар шинэчлэл"ХХК-ний автобааз | БЗД-ийн 11-р хороо Хонхор-82 "Сэнтрал фүүдс"ХХК-ний үйлдвэрийн байр | БЗД-ийн 22-р хороо Цагаан давааны төвлөрсөн хогны цэг |
| 0261 УНГ | СХД-ийн 36-р хороо Алтан овоо хэсэг "Улаанбаатар шинэчлэл"ХХК-ний автобааз | БЗД-ийн 11-р хороо Хонхор-82 "Сэнтрал фүүдс"ХХК-ний үйлдвэрийн байр | БЗД-ийн 22-р хороо Цагаан давааны төвлөрсөн хогны цэг |
| 6458 УНП | СХД-ийн 36-р хороо Алтан овоо хэсэг "Улаанбаатар шинэчлэл"ХХК-ний автобааз | БЗД-ийн 11-р хороо Хонхор-82 "Сэнтрал фүүдс"ХХК-ний үйлдвэрийн байр | БЗД-ийн 22-р хороо Цагаан давааны төвлөрсөн хогны цэг |

*Хавсралт -2*

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС

# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000201150

2007.12.05
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011305038
/ Хувийн хэргийн дугаар /

5183383
/ Регистрийн дугаар /

Улаанбаатаршинэчлэл Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2007.11.23 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 8411 | Хотын тохижилт үйлчилгээ |
| 8299 | Орчуулга хийх үйлчилгээ |
| 0130 | Цэцэрлэгжүүлэлт |
| 1511 | Хоёрдогч түүхий эд боловсруулах |
| 4390 | Гэрэлтүүлэг, реклам чимэглэл хийх |
| 7911 | Аялал жуулчлал |
| 4330 | Барилгын засвар хийх |
| 9820 | Айл аж ахуй нэгж байгууллага дуудлагаар нүүлгэх |

| Хугацаагүй | 1 | 1,000.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Баянгол, 18-р хороо, жалханц хутагт дамдинбазар, 37, 5 тоот, Утас1: 77015050, Утас2: 94505050, Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

МОНГОЛ УЛС МОНГОЛ УЛС МОНГОЛ УЛС

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

*Гэрчилгээ дахин олгосон 2020 он 04 сар 03 өдөр*

*Хавсралт №2*

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл**

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | *Батсүх овогтой Эрдэнэсайхан-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.*<br>*9810 Дуудлагын гэр цэвэрлэгээ*<br>*1391 Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа* | *2013.03.11* | Э.Мөнхзаяа |
| 2 | *Дахин гэрчилгээ олгов.* | *2020.04.03* | *Э.Эрдэнэбилэг* |

"УЛААНБААТАР ШИНЭЧЛЭЛ"ХХК *Хавсралт №3*

"СЭНТРАЛ ФҮҮДС" ХХК-ний хог хаягдал тээвэрлэх автомашины мэдээлэл

2023 он

| | | | |
|---|---|---|---|
| **Тээврийн хэрэгслийн дугаар** | 0757 УАМ | 0261 УНГ | 6458 УНП |
| **Арлын дугаар** | FD3HKA21125 | FD3HGA51026 | KL3K4D6F1CK004780 |
| **Тээврийн хэрэгслийн марк** | Hino ranger | Hino ranger | DAEWOO TATA-K4D6F |
| **Бүх жин** | 7 950 | 10 400 | 26 029 |
| **Өөрийн жин** | 2 950 | 5 400 | 11 020 |
| **Даац** | 5 000 | 5 000 | 15 000 |
| **Зориулалт** | Тусгай зориулалт Хог тээвэрлэлт | Ердийн тэвштэй Хог тээвэрлэлт | Өөрөө буулгагч Хог тээвэрлэлт |
| **Өмчлөгч** | Улаанбаатар шинэчлэл ХХК | Улаанбаатар шинэчлэл ХХК | Улаанбаатар шинэчлэл ХХК |
| **Жолоочийн нэр** | Б.Баасанбат | Э.Буянмэх | Д.Үнэнхүү |

*Хавсралт№3*


МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ
CITIZEN IDENTITY CARD OF MONGOLIA
Овог
Боржигон
Эцэг/ эх /-ийн нэр
Дашдорж
Нэр
ҮНЭНХҮҮ
Хүйс
Эрэгтэй
Төрсөн он, сар, өдөр
1968-04-04
Регистрийн дугаар
ГК68040478


Олгосон байгууллага Issuing authority
Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
The General Authority for State Registration
Олгосон он, сар, өдөр
2021/08/24
Хүчинтэй хугацаа
0000/00/00
Хаяг
УБ, Сонгинохайрхан, 26-р
хороо@мандал овоо 18 гудамж@35
тоот


ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХ
Mongolian driver's license
Ургийн овог / Family name
БОРЖИГОН
BORJIGON
Үнэмлэхний дугаар / License number
№ 175162
Эцэг /эх/-ийн нэр / Surname
ДАШДОРЖ
DASHDORJ
B C E
Цусны бүлэг / Blood type
A(II)
Нэр / Given name
ҮНЭНХҮҮ
UNENKHUU
Хүйс / Sex
Эр /m/
ДГ68040478
Төрсөн он / Date of birth
1968-04-04
Олгосон байгууллага Замын Цагдаагийн Газар
Police Department of Mongolia


MGL PERMIS DE CONDUIRE
A
B
C
D
E
2012-10-04
2022-10-04
2012-10-04

*Хавсралт №3*



CONDUIRE
A
B
C
D
E
M
2012-01-31
2003-05-16
2022-01-31
2012-01-31
2003-05-16
2012-01-31
77272




ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХ
БОРЖИГИН
№ 77272
БАТСАЙХАН
БААСАНБАТ
1976-07-30

*Хавсралт №3*


МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ
Боржигон
Эрдэнэтуяа
БУЯННЭМЭХ
Эрэгтэй / Male
1975/10/25
УБ75102514 / UB75102514


Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
2012/09/10
2020/10/26
УБ, Чингэлтэй, 8-р хороо
224 тоот


ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХ
Mongolian driver's license
БОРЖИГОН
BORJIGON
№ 538928
ЭРДЭНЭТУЯА
ERDENETUYA
БУЯННЭМЭХ
BUYANNEMEKH
УБ75102514
1975-10-25


MGL PERMIS DE CONDUIRE
A
B
C
D
E
M
2008-07-28
2017-11-10
2027-11-10

*Хавсралт №3*

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Technical specifications

MGL

ГЭРЧИЛГЭЭ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА
Certificate issuing authority

№ 03580113

TECHNICAL INSPECTION

САНАМЖ

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ӨМЧЛӨГЧ ТА

MONGOLIA

CERTIFICAT D'IMMATRICULATION DU VEHICULE

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

CERTIFICATE OF VEHICLE REGISTRATION

MGL

№ 02989559

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Technical specifications

MGL

ГЭРЧИЛГЭЭ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА
Certificate issuing authority

№ 02989559

*Хавсралт №3*

БАТЛАВ:
"СЭНТРАЛ ФҮҮДС" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ЖҮГДЭРНАМЖИЛ

# ХЭРЭГЛЭСЭН ТОС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Улаанбаатар хот Дугаар PD-2023-022 2023 он... сар....өдөр

Энэхүү гэрээг нэг талаас Монор-Улз ХХК төлөөлөн Гүйцэтгэх захирал Э.Энх-Амгалан (цаашид Худалдан авагч гэх) нөгөө талаас Сэнтрал фүүдс ХХК төлөөлөн Чанарын алба хариуцсан менежер А.Ундраа (цаашид Худалдагч) гэх нар Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох зүйл заалтыг үндэслэн дараах нөхцөлтэйгээр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

## 1. Гэрээний агуулга

1.1 Энэхүү гэрээнд заасны дагуу Худалдагч нь хэрэглэсэн тосыг тусгай урьдчилан байршуулсан саванд цуглуулж Худалдан авагчид хүлээлгэн өгөх Худалдан авагч нь барааг хүлээн авч гэрээнд заасны дагуу төлбөрийг төлнө.

1.2 Барааны нэр, төрөл: Хэрэглэсэн ургамлын тос

## 2. Нийлүүлэх хугацаа, нөхцөл

2.1 Худалдагч тал хэрэглэсэн тосоо урьдчилан хурааж, Худалдан авагч талд 7 хоног бүрийн 4 дэх өдөр бүр хүлээлгэн өгнө.

2.2 Хэрэглэсэн тосонд ус, аливаа шингэн зүйл холихгүй байх.

2.3 Худалдан авагчийн байршуулсан саванд тосыг халуунаар нь хийхгүй бөгөөд тодорхой температурт хүртэл хөргөж хийх

2.4 Худалдан авагч тал барааг хүлээн авах хүртэл тосыг аливаа гэмтэл эвдрэл, устахаас сэргийлж аюулгүй байдлыг хангаж хадгалах.

## 3. Үнэ төлбөр

3.1 Хэрэглэсэн тосны нэг литр тутмын үнэ 50 төгрөг болно.

3.2 Худалдан авагч нь хэрэглэсэн тосыг хүлээн авахдаа бараа хүлээлцэх хуудсыг болон орлогын баримт бөглөн хоёр тал нэг нэг хувийг хадгалан үлдэх ба сарын сүүлд тооцоо нийлэн төлбөрийг бүрэн төлнө.

## 4. Барааг хүлээн авах

4.1 Худалдагч нь Худалдан авагч талаас урьдчилан байршуулсан тосыг 7 хоног бүрийн 4 өдөр Худалдан авагч тал руу мэдэгдэн барааг хүлээлгэн өгнө.

4.2 Талууд хүлээн авах цэг дээр тосны тоо хэмжээг шалган бараа хүлээлцэх акт үйлдэнэ.

## 5. Гэрээний хүчин төгөлдөр байдал

5.1 Энэхүү гэрээ нь 2023 оны 02 сарын 10-ний өдрөөс эхлэн 1 /нэг / жилийн хугацаанд үргэлжилнэ. Аль нэг тал гэрээг цуцлах хүсэлт гаргаагүй бол энэхүү гэрээ нь анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

## 6. Талуудын үүрэг хариуцлага

6.1 Худалдан авагч дараах үүрэг хүлээнэ:

Гэрээний дагуу худалдагч талаас тосыг цуглуулан авч тооцоо нийлсний үндсэн дээр үнийг төлнө.

6.2 Худалдагч дараах үүрэг хүлээнэ:

Гэрээний дагуу тосыг хадгалан цуглуулж худалдан авагч талд хүлээлгэн өгч тооцоо нийлнэ.

**7. Маргаан шийдвэрлэх**

7.1 Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

**8. Гэрээнд нэмэлт өөрчлөлт хийх**

8.1 Энэхүү гэрээний нөхцөлийг талуудын хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан баримт бичгийн дагуу өөрчилж, нэмж болно.

8.2 Талууд нөгөө талын бичгэн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй.

**9. Бусад нөхцөл**

9.1. Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ нөгөө талынхаа албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчилсэн байдлаар буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй.

9.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээ болон гэрээний хавсралтад бичгийн хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.4. Гэрээг талууд хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд эдгээр хувь бүр хуулийн хүчин төгөлдөр байна.

9.5. Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

| **Худалдагчийг төлөөлж** | **Худалдан авагчийг төлөөлж** |
|---|---|
| Сэнтрал фүүдс ХХК | Монор-Улз ХХК |
| Чанарын алба хариуцсан менежер | Гүйцэтгэх захирал |
| ________________ | ________________ |
| Г.Ундраа | Э.Энх-Амгалан |
| Хаяг: БЗД, 11-р хороо Хонхор-82 | Хаяг: ХУД, 3-р хороо, ганбармат |

МОНОР-УЛ... ХХК

Норовням НАРАНТУЯА
narantuya5818@gmail.co
Өмгөөллийн авинекс па